

БАТЛАВ.
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д. ДУЛАМ

2020 оны 03 дугаар сарын 06 өдөр

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ
“УС ЗӨӨВРИЙН АВТОМАШИН” ХУДАЛДАН АВАХ
ГҮЙЦЭТГЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт:

**Дэлгэрэх сумын ЗДТГ-т “Ус зөөврийн
автомашин” нийлүүлэх гүйцэтгэгч сонгох**

Гэрээний нэр дугаар:

ХА/2020/03

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Дэлгэрэх суманд “Ус зөөврийн автомашин”* нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн санал авах тендерийн баримт бичгийг “Tender.gov.mn” цахимаар хүсэлтээ гаргаж түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн 16 цаг 00 минутаас** өмнө “Tender gov.mn” цахим хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн 16 цаг 30 минутад нээнэ.**

Тендертэй холбоотой саналыг Дорноговь аймаг Дэлгэрэх сумын ЗДТГазарт, Сумын Засаг даргын орлогч Р.Сосорбарам утас: 91103933, Soogii1002@gmail.com хаягаар ирүүлнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн буюу 2019, 2018 оны санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн буюу 2019, 2018 онд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар хавсаргана/;</p> <p>Ижил төстэй ажлыг нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 2 жилд буюу 2018-2019 онуудад ядаж нэг удаа 40.0 сая төгрөг буюу түүнээс дээш өртөг бүхий ижил төстэй ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байх/</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Гадаад худалдаа</p> <p>Бусад нэмэлт шаардлага: Óëñúí á¿ðòáýéèéí äýð÷èèäýýíèé ààòàèääàæñàí òóóéáàð - Òóñààé ç°áø°ðèèéí ààòàèääàæñàí òóóéáàð - Òáíáàðò îðíèõîã÷-ééä ò°è°èæ äàðúí ¿ñýã çóðñàí ýòäýýäéí èòäýíæéýè - Òàðèèòàà÷ ààíèíú òíáíðõíééíèò /°ðã¿é ààéõ/ - Òàòààðúí äàçðúí òíáíðõíééíèò /°ðã¿é ààéõ/ - Íééáíééí ààòàèääèúí äàçðúí òíáíðõíééíèò /°ðã¿é ààéõ/</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Дорноговь аймаг Дэлгэрэх сум 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр</p> <p>Байгууллагын хаяг: Дэлгэрэх сум 4-р баг ЗДТГазар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Tender.gov.mn</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 13-ний өдөр</p> <p>Цаг: 16 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Дэлгэрэх сумын ЗДТГазар, Засаг даргын орлогч өрөө</p> <p>Давхар: 1 давхар ЗДТГазар, Засаг даргын орлогч өрөө №4</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 13-ний өдөр</p> <p>Цаг: 16 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 15.1	Тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлэх

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ажил, барааны тодорхойлолт:

№	Нэр төрөл	Хэмжих нэгж
1	Үйлдвэрлэсэн улс	Япон болон Солонгос улсын бол давуу тал болно
2	Үйлдвэрлэсэн он	Шинэ, 2010 оноос хойш үйлдвэрлэгдсэн.
3	Зориулалт	Ундны усны
4	Төрөл	Тусгай
5	Хөдөлгүүр	Тодорхой заахгүй
6	Түлш зарцуулалт	100км-д 15 литрээс илүүгүй байна.
7	Багтаамж /даац/	5 тн дээш
8	Өнгө	Заахгүй
9	Дугуй	7 ш
10	Машины тоноглол	Хөгжим, кондейшнтэй
11	Бусад хэрэгсэл	Дугуйн торцов, ком түлхүүр, галын хор, ослын гурвалжин, эмийн сан, домкрат
12	Автомашины зураг	Нийлүүлэх автомашины зураг

2. **Стандарт:** Усны агуулах сав нь 5тн - оос дээш багтаамжтай байх бөгөөд нержи буюу зэвэрдэггүй, хайши /цайран/ доторлогоотой байна. Өвлийн дулаалгатай байна.
3. **Ажил хийгдэх газар:** Дорноговь аймаг Дэлгэрэх сумын иргэдийн ундны усыг түгээхэд ашиглагдана.
4. **Ажил, бараа нийлүүлэлтийн хуваарь:** Ус зөөврийн атвомашиныг ажлын гүйцэтгэлийг гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор хийж гүйцэтгэнэ.
5. **Бусад:** Тээврийн хэрэгслийн татвар, гэрчилгээ, улсын дугаар, даатгалтай холбоотой хөрөнгийг гүйцэтгэгч компаниар гаргуулна.

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЧИМЭДРЭГЗЭН
НЯГТЛАН БОДОГЧ Г.ЦЭЭЦПИЛМАА



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерг оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг барааг хүлээн авч нэхэмжлэх хүлээн авснаас хойш шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. Ажил, барааг хүлээн авахдаа нягтлан шалгаж хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага. /1жил/
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 4.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 4 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.
- 4.2 Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш ажлын 14 хоног байна.
- 4.3. Магадлашгүй ажлын зардал 2%
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹** 5.1 Алданги оногдуулах хувь: Хоногт **0.5** хувь
- Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10** хувиас тус тус хэтрэхгүй